



МОНГОЛ УЛС  
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603  
Цахим шуудан: info@bo.gov.mn  
Цахим хаяг: http://bayan-olgii.gov.mn/

2025-12-23 № 1-01/1766  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Г.ЭНХБАТ ТАНАА

*Баттөр*

*Номхон*


*Э.М/Б, д.Х.*

Санал хүргүүлэх тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан "Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журам"-ын дагуу шилдэг өвлөн уламжлагчийн шагналд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын оршин суугч, Урианхай сурын дархан мэргэн Мичирийн Батгэрэлийг тодруулан нэр дэвшүүлж байна.

Иймд 2025 оны үндэсний болон олон улсын хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх санаачилгатай оролцсон өвлөн уламжлагчийн холбогдох баримт бичгийг дээрх журмын дагуу бүрдүүлэн хүргүүлж байна.

Хавсралт 30 хуудастай.



Б.ЗАНГАР

8325032170



МОНГОЛ УЛС  
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603  
Цахим шуудан: [info@bo.gov.mn](mailto:info@bo.gov.mn)  
Цахим хаяг: <http://bayan-olgi.gov.mn/>

2025-12-23 № 1-01/1766  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан "Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журам"-ын дагуу шилдэг өвлөн уламжлагчийн шагналд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын оршин суугч, Урианхай сурын дархан мэргэн Мичирийн Батгэрэлийг тодруулан нэр дэвшүүлж байна.

Иймд 2025 оны үндэсний болон олон улсын хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх санаачилгатай оролцсон өвлөн уламжлагчийн холбогдох баримт бичгийг дээрх журмын дагуу бүрдүүлэн хүргүүлж байна.

Хавсралт 30 хуудастай.



Б.ЗАНГАР

8325032170



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

Нэгдсэн эмнэлэг 1-р гудамж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв,  
4-р давхар, 11 дүгээр баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг, 83129,

Утас/Факс: 70422289

Цахим шуудан: [Info@bo.mos.gov.mn](mailto:Info@bo.mos.gov.mn)

Цахим хуудас: [www.bu-soyol.com](http://www.bu-soyol.com)

2025.12.24 № 373

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Г.ЭНХБАТ ТАНАА

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.5 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу тус аймгаас нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагчийн баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлж байна.

Хавсралт 3<sup>хуудастай</sup>.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ӨЛЗИЙТУНГАЛАГ




[illegible]

بعض من بعض من بعض و بعض  
بعض من بعض من بعض


[illegible]

وزارت معادن و صنایع معدنی  
وزیران  
معاونین  
مجلس شورای ملی  
کتابخانه  
تاریخ  
شماره

[illegible]

مصدق من اصدق من مصغره و  
مصدق من مصغره - و - مصغره مصغره

پیشہ ورانہ تعلیم و محنت

[illegible]



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас: (976) 7042-2184

2025.12.18 № 1/578

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТОДОРХОЙЛОЛТ

Монгол улсын мэргэн, Урианхай сурын дархан мэргэн, Буриад сурын улсын мэргэн Мичирийн Батгэрэл нь орон нутагтаа болон улсад Урианхай сурыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд их хувь нэмэр оруулж, олон шавь нар болон Баян-Өлгий аймгаас олон мэргэчүүд, харваачдыг сургаж хүмүүжүүлсэн юм.

Урианхай сурыг хөрш зэргэлдээ Казахстан улс, Оросын холбооны Тува улс болон зэргэлдээ хөрш аймгуудад хөгжүүлэхэд Сурын холбоотойгоо хамтран үр бүтээлтэй ажиллаж байна.

Иймд М.Батгэрэлийн Урианхай сурын хөгжилд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж Соёлын яамнаас жил болгон зохион байгуулдаг "Шилдэг өвлөн уламжлагч" шагналд тодорхойлон уламжилж байна.

ЗАСАГ ДАРГА



Х.БОЛАТБЕК



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг  
Т.Авдигажийн гудамж 100, Утас: 7042-2725  
Цахим шуудан: [bayan-ulgii@sport.gov.mn](mailto:bayan-ulgii@sport.gov.mn)  
Цахим хуудас: [bayan-ulgii.sport.gov.mn](http://bayan-ulgii.sport.gov.mn)

2015. 12. 18 № 155

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АЙМГИЙН СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАРТ**

Монгол Улсын мэргэн, Урианхай сурын дархан мэргэн, Буриад сурын улсын мэргэн М.Батгэрэл нь аймагтаа болон улсад урианхай сурын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, олон шавьтай, тус аймгаас олон мэргэчүүд, харваачдыг бэлтгэн тэмцээн уралдаанд амжилттай оролцуулж байгаа билээ.

М.Батгэрэл нь “Тод Баруун Алтай” урианхай сурын сургалтын клуб байгуулж, тус байгууллагатай олон жил хамтран ажиллаж байна.

Иймд М.Батгэрэлийн урианхай сурын өв соёлыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, хичээл зүтгэлийг үнэлж “Шилдэг өвлөн уламжлагч” шагналд тодорхойлон уламжилж байна.

СПОРТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА  Б.САНАТ



# ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН МАТЕРИАЛЫН БҮРДЭЛ

## Баян-Өлгий аймаг Өлгий сум

|                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
| <div> <div>Нэр дэвшигчийн овог</div> <div> <div>Нэр:</div> <div>-Нас</div> <div>-Хүйс</div> <div>-ЗНэгж</div> </div> <div> <div>Өвийн төрөл зүйл</div> <div>-Хэдэн жил өвлөсөн:</div> </div> </div> <div>д/д</div> | <div>Хавсаргах баримт бичиг</div> <div> <div>Шагналд нэр дэвшүүлсэн үндэслэл бүхий Аймаг, Нийслэлийн Засаг хдаргын албан тооттой эсэх</div> <div>Албан бичгийн ирсэн огноо</div> <div>СӨххрхҮТөвд хүлээн авсан огноо</div> <div></div> <div>Ур чадварын өндөр түвшинд өвлөгчөөр бүртгэгдсэн</div> <div> <div>Холбогдох баримт бичиг, гэрэл зураг, дүрс бичлэг, бусад</div> <div>Дүрс бичлэг/минут</div> <div>Гэрэл зураг/ш</div> <div>Баримт бичиг</div> <div>бусад</div> </div> </div> |  |  | <div>Нэр дэвшүүлэх шалгуур, үндэслэл</div> <div> <div>байгуулагдсан уралдаан, тэмцээнд амжилт гаргасан</div> <div> <div>Дотоод</div> <div>Гадаад</div> </div> <div>дэлгэрүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон байдал</div> <div> <div>Дотоод</div> <div>Гадаад</div> </div> <div>ийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад арга хэмжээ зохион байгуулсан</div> <div> <div>Дотоод</div> <div>Гадаад</div> </div> <div> <div>Шавь сургалт/хэд</div> <div>Судалгаа шинжилгээ хийсэн эсэх</div> <div>Холбогдох Төрийн байгууллагатай хамтран ажилласан</div> </div> <div>СББӨ-ийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачлагатай оролцсон</div> </div> |  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

**Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Сурын холбооны тэргүүн болон  
ахмад залуу гишүүдийн хурлын тэмдэглэл**

**2025.12.18**

Харваачдын хурлыг 2025 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 14:00цагт Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2-р БДС хурлын танхимд хийв. Хуралд нийт 20 харваач оролцож, 98% ирцтэйгээр хуралдав. Хурлыг тус аймгийн сурын холбооны тэргүүн М.Төртулга удирдав.

**Хэлэлцэх асуудал:**

Тус сурын холбооны Монгол Улсын мэргэн багш дасгалжуулагч Мичир овогтой Батгэрэлийг “Өвлөн уламжлагч” шагнуулахаар нэрийг нь дэвшүүлж байгааг мэдэгдэж, шагнуулах болзол журмыг танилцуулав.

**Сурын холбооны тэргүүн М.Төртулга**

Тус сурын холбооны багш дасгалжуулагч, М.Батгэрэл нь он удаан жил тогтвор суурьшилтай, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүний багш дасгалжуулагчийн нэг юм. Ажиллах хугацаандаа хүүхэд багачуудын бие бялдрыг хөгжүүлэх, тамирчдын бие даан ажиллах чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарч зохих үр дүнд хүрч амжилт гаргасан тэргүүний багш дасгалжуулагч юм. М.Батгэрэл нь заах өндөр ур чадвартай өөрийн, мэдлэг туршлагаа залуу харваачдад зааж зөвлөж, өөрөө болон шавь нар нь улс аймагтаа “Тэргүүн байр” эзэлж, олон чадварлаг мэргэчүүдийг шинээр гаргаж улсдаа өөрийн нэрээ дурсгасан Тэргүүний харваач юм. Иймд М.Батгэрэл харваачийг “Өвлөн уламжлагч” шагналаар шагнуулахаар санал оруулж байна. Та бүхэн өөрийн санал бодлоо хэлнэ үү.

**Ахмад харваач Ч.Жамбал**

Харваач М.Батгэрэл нь харваач бүртэй тулж ажиллах арга барилыг сайн эзэмшсэн. Багаар ажиллах чадвартай. Залуу харваачдыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах талаар зөвлөн тусалж, арга зүйн зөвлөгөө байнга өгдөг. Заах ур чадвар, ажлын туршлага нь аймаг улс болон олон улсдаа танигдаж, нийт харваачдаа нэрийг төрийн дээд шагналд дэвшүүлэхийг дэмжиж байна.

**Спортын мастер Ж.Бямбадорж**

Мэргэн С.Батгэрэл нь 30 дэх жилдээ үр бүтээлтэй ажиллаж байгаа манай сурын холбооны тэргүүний харваачдын нэг юм. Багшлах ур чадвар өндөртэй. Багш дасгалжуулагч М.Батгэрэл нь заах ур чадвар, ажлын туршлага нь аймаг, улсдаа болон олон улсад танигдаж, мэргэжил нэгт харваачдаа манлайлан, олон жил тогтвортой үр бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүлэх зэрэгтэй Монгол Улсын мэргэн дасгалжуулагч багш юм. Багш

М.Батгэрэл нь хамт олон болон шавь нартаа нэр хүндтэй, нөхөрсөг, тусч, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог тэргүүний багш дасгалжуулагч, юм.

2019 оноос эхлэн Тод баруун аймаг үндэсний сурын клуб байгуулан үндэсний болон байт харвааны сургалт явуулж 30 гаруй хүүхдийг харваагаар хичээллэж байгаа.

**Урианхай сурын улсын мэргэн Үндэсний сурын спортны мастер:Х.Алтансум**

Монгол Улсын мэргэн дасгалжуулагч М.Батгэрэл нь залуу үеийн харваачдыг улсын баяр наадам болон Улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай бэлтгэж оролцуулж байна. Уг амжилт нь олон залуу харваачдаар хүрээгээ тэлэн өргөжиж байна. Баян-Өлгий аймагт сур хөгжүүлэхэд өөрийн хүч хөдөлмөр авьяас чадвараа харамгүй зориулж ирсэн хүн бол яахын аргагүй Монгол Улсын мэргэн багш дасгалжуулагч М.Батгэрэл юм. Энэ шагналд тодорхойлох нь зүйтэй юм. Санал нэгтэй дэмжиж байна.

**Урианхай сурын улсын мэргэн: Т.Очироо**

Монгол Улсын мэргэн багш дасгалжуулагч М.Батгэрэл нь бид бүхэнд маш олон зүйлийг зааж сургасан. Он удаан жил сурын спортоор хичээллэж аймаг улсын аварга шалгаруулах, тэмцээн, уралдаанд амжилттай оролцож байсан хүн юм. Хийсэн хөдөлмөр бүтээлийг нь үнэлж энэ шагналд тодорхойлох нь зүйтэй юм.

**Сурын холбооны тэргүүн:С.Алтанцоож**


Монгол Улсын мэргэн багш, дасгалжуулагч М.Батгэрэлийн ажлын амжилтыг сайшаан тэмдэглэж, 2024 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн хамт олны хурлаас Өвлөн уламжлагч шагналт шагнуулахаар хамт олны 100%-ийн саналаар шийдвэрлэснийг үндэслэн тодорхойлов.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН СУРЫН  
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН



М.ТӨРТУЛГА

## ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ ХАРВААЧ МИЧИРИЙН БАТГЭРЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Мичирийн Батгэрэл нь 1968 онд Баян-Өлгий аймгийн Буянт суманд төрсөн, урианхай угсааны уламжлалт сурын харваач, ахмад багш, сурын харвааны биет бус соёлын өвийг өвлөн уламжлагч юм.

Тэрээр бага наснаасаа эхлэн эцэг эх, ахмад үеэсээ урианхай сурын харвааны арга ухаан, ёс жаягийг өвлөн сурч, уламжлалт харвааг тасралтгүй эзэмшин хөгжүүлж ирсэн бөгөөд өдгөө 40 гаруй жилийн хугацаанд уг өвийг хадгалан

хамгаалах, хойч үед уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр тууштай ажиллаж байна.

М.Батгэрэл нь Монголын харваачдын холбоо болон уламжлалт сурын харвааны арга ухааныг хөгжүүлэх, хамгаалах, сурталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын идэвхтэй гишүүнээр олон жил ажилласан. Тэрээр Монгол Урианхай сурын Тэргүүлэгчээр ажиллаж байх хугацаандаа урианхай сурын харвааны дүрэм, журмыг боловсронгуй болгох ажлыг санаачлан хэрэгжүүлж, уг уламжлалт өвийг спортын төрөл хэлбэрт шилжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.

Олон улсын түвшинд Монголын уламжлалт сурын харвааг сурталчлан таниулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, 2012 онд Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан уламжлалт харвааны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон. Мөн 2013–2014 онуудад Бүгд Найрамдах Казахстан Улсад морьт харваа болон урианхай сурын харвааг залуу харваачдад сурталчлан таниулах, дадлагажуулах, сургах үйл ажиллагааг зохион байгуулж, багш, дасгалжуулагчийн үүргийг гүйцэтгэсэн.

Түүний сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үр дүнд урианхай сурын харвааны арга барил, уламжлалт ёс жаягийг өвлөсөн олон залуу харваач бэлтгэгдэж, уг өвийг цаашид хадгалан хамгаалах суурь бүрдсэн байна.

Түүнчлэн М.Батгэрэл нь олон улсын хэмжээний уламжлалт харвааны арга хэмжээнд шавь нараа удирдан оролцож, багш, сургагчийн хувиар идэвхтэй ажилласан. Тэрээр Бүгд Найрамдах Казахстан Улсын Атырау хотод зохион байгуулагдсан уламжлалт харвааны дэлхийн хэмжээний тэмцээнд шавь нараа удирдан оролцож, Монголын урианхай сурын харвааны арга барил, ёс заншлыг олон улсад сурталчлан таниулж, уг арга хэмжээнд амжилттай оролцсон байна.

Мөн 2025 оны 8 дугаар сард Оросын Холбооны Улсын Барнаул хотод зохион байгуулагдсан “Алтай нурууны улс, аймгууд” олон улсын арга хэмжээний хүрээнд урианхай сурын харвааны сургалт, дадлагын үйл ажиллагаанд оролцож, шавь нарын хамтаар урианхай сурын чих, сум, эрхийвч, агсуурга, мөн сургалтын зориулалттай уламжлалт нум зэргийг биечлэн хамтран урлан хийж, сургалтын үйл ажиллагаандаа ашигласан.

Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан урианхай сурын харвааны зэвсэг хэрэгслийг уламжлалт арга технологиор бэлтгэх мэдлэг, ур чадварыг залуу харваачдад заан сургаж,

онол-дадлагыг хослуулсан сургалтыг зохион байгуулж, биет бус соёлын өвийг бодитоор өвлүүлэн уламжлуулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Урьд нь шагнагдаж байсан шагналууд: /Монгол Улсын цол, одон медаль, яамны “Жуух бичиг” болон бусад/

| №   | Шагналын нэр                                                                                  | Хэдэн онд |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------|-----------|
| 1.  | Урианхай сурын “Сумын мэргэн”                                                                 | 1993он    |
| 2.  | Аймгийн аварга шалгаруулах урианхай сурын тэмцээн “Тэргүүн байр”                              | 1995он    |
| 3.  | Урианхай сурын “Аймгийн мэргэн”                                                               | 1996он    |
| 4.  | Үндэсний сурын “Аймгийн мэргэн”                                                               | 1997он    |
| 5.  | Үндэсний сурын “Аймгийн хошой мэргэн”                                                         | 1997он    |
| 6.  | Үндэсний баяр наадмын үндэсний сурын төрөлд тэргүүн байр эзлэж “Улсын мэргэн, цол”            | 1998он    |
| 7.  | Үндэсний сурын Урианхай сурын төрөлд багаараа тэргүүн байр, хувийн амжилтаараа “Тэргүүн байр” | 1998он    |
| 8.  | Ховд аймаг “Алтай унага даншиг наадмын түрүү байр” Даншиг мэргэн, цол                         | 1999он    |
| 9.  | Үндэсний Их баярын наадмын Урианхай сурын харваанд түрүүлж, Урианхай сурын “Улсын мэргэн”     | 2000он    |
| 10. | Улсын аварга шаогаруулах Урианхай сурын тэмцээний Дэд байр                                    | 2001он    |
| 11. | Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын төрөлд 3-байр                                         | 2002он    |
| 12. | Аймгийн шилдэг тамирчин                                                                       | 2002он    |
| 13. | Аймгийн аварга шалгаруулах Үндэсний сурын төрөлд “Тэргүүн байр”                               | 2003он    |
| 14. | Улсын аварга шалгаруулах Үндэсний сурын төрөлд 3-р байр                                       | 2003он    |
| 15. | Аймгийн аварга шалгаруулах Урианхай сурын төрөлд “Тэргүүн байр”                               | 2004он    |
| 16. | Улсын аварга шалгаруулах Урианхай сурын төрөлд “Дэд байр”                                     | 2004он    |
| 17. | Аймгийн аварга шалгаруулах Урианхай сурын төрөлд “Тэргүүн байр”                               | 2005он    |
| 18. | Улсын аварга шалгаруулах Урианхай сурын төрөлд “Дэд байр”                                     | 2005он    |
| 19. | Үндэсний их баяр наадмын Урианхай сурын төрөлд 3-р байр                                       | 2006он    |
| 20. | Аймгийн аварга шалгаруулах Урианхай сурын тэмцээнд “Тэргүүн байр”                             | 2007он    |

|     |                                                                                                                                         |         |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|
| 21. | Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын төрөлд 30 сумнаас 27 онож дээд амжилт тогтоон Урианхай сурын Улсын "Хошой мэргэн"               | 2007он  |
| 22. | Аймгийн шилдэг тамирчин                                                                                                                 | 2007он  |
| 23. | Үндэсний Их баяр наадмын Буриад сурын харваанд Тэргүүн байр эзэлж, Буриад сурын "Улсын мэргэн" "Спортын мастер" цол                     | 2008он  |
| 24. | Баян-Өлгий аймаг үүсч хөгжсөний 70 жилийн ойн Үндэсний сурын харваанд "Дэд байр"                                                        | 2010он  |
| 25. | Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын төрөлд 5-р байр                                                                                 | 2010он  |
| 26. | Улсын аварга шалгаруулах Урианхай сурын төрөлд 4-байр                                                                                   | 2011он  |
| 27. | Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын төрөлд 30 сумнаас 28 онож дээд амжилт тогтоон "Тэргүүн байр" Урианхай сурын "Дархан мэргэн цол" | 2012он  |
| 28. | Улсын аварга шалгаруулах Үндэсний сурын харваанд 4-р байр                                                                               | 2014он  |
| 29. | Улсын аварга шалгаруулах Урианхай сурын төрөлд 5-р байр                                                                                 | 2015он  |
| 30. | Өвлийн мөсөн сурын Улсын аварга шалгаруулах тэмцээнд Тэргүүн байр                                                                       | 2017он  |
| 31. | Заалны саран байны харваанд Тэргүүн байр                                                                                                | 2017он  |
| 32. | Ж.Ноост агсны нэрэмжит Урианхай сурын нээлтийн харваа 5-р байр                                                                          | 2024 он |
| 33. | Өмнө гол багийн Үнхэлцгийн овоо тахилгын харваа 3-р байр                                                                                | 2025 он |

- Үндэсний их баяр наадмын Үнэсний сурын төрөлд Тэргүүн байр эзэлж, "Улсын мэргэн" цол
- Үндэсний спортын анхдугаар Их наадмын Урианхай сурын төрөлд багаар "Тэргүүн байр"
- Ховд аймагт "Алтайн Унага" даншинг наадмын түрүү байр эзэлж "Даншгийн мэргэн цол"
- Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын харваанд түрүүлж, Урианхай сурын "Улсын мэргэн"
- Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын төрөлд 30 сумнаас 27 онож дээд амжилт тогтоон Урианхай сурын Улсын "Хошой мэргэн"
- Үндэсний Их баяр наадмын Буриад сурын харваанд Тэргүүн байр эзэлж, Буриад сурын "Улсын мэргэн", Спортын мастер" цол
- Үндэсний Их баяр наадмын Урианхай сурын сурын төрөлд 30 сумнаас 28 онож дээд амжилт тогтоон "Тэргүүн байр" Урианхай сурын "Дархан мэргэн" цол

- Үндэсний их баяр наадмын харваанд үндэсний болон урианхай буриад сурын харваанд нийтдээ 5 түрүү авсан. Жил бүр Үндэсний баяр наадмын Урианхай болон Үндэсний сур харваанд шавь нарын хамт Тэргүүн, Дэд байранд шалгардаг. Мөн Баян-Өлгий аймгийн баяр наадам болон аварга шалгаруулах тэмцээнүүдэд 8 удаа "Тэргүүн байр" эзэлсэн.
- Үндэсний сураар олон жил хичээллэж жил бүр зохион байгуулагддаг тэмцээнүүдэд тэргүүлж, шавь гараас нь аймаг улсын цолтой олон харваачид төрөн гаосан.
- 2013 онд Нурсултан хотол урилгаар очиж Казакын үндэсний сур болон Жанбы Ату харвааг сургаж, олон тамирчдыг бэлтгэн гаргасан.
- Аймгийн Манлай харваачаар 3 удаа шалгарсан.
- "Ерөнхийлөгчийн Цом"-ын тэмцээнд оролцсон.

Телевизийн нэвтрүүлэг:

<https://www.facebook.com/watch/?v=1202728586471958> "MNB Бахархал нэвтрүүлэг"

<https://www.facebook.com/NTVNewsMN/videos/765633154419895> "NTV нэвтрүүлэг"

"Саян цахим телевиз" Нэгэн жарны эзэд нэвтрүүлэг


Өлгий радио ярилцлага <https://www.facebook.com/61557287247172/>



Мэргэн харваачдын өлгий нутаг. Анх Баян-Өлгий аймаг байгуулагдсаны 10 жилийн ойгоор 1950 онд баяр наадмын хөтөлбөрт оруулж, урианхай сурын харвааг аймгийн төвд зохион явуулж байсан түүхтэй. Сумдаас ирсэн 30 гаруй харваа оролцсоноос Алтанцөгц сумын харьяаг Т.Цагаан 36 сумнаас 30 онож түрүүлж байжээ. Энэ цагаас хойш урианхай сурын харваа баяр наадмаар тасралтгүй үргэлжилжээ. 1998 онд Ардын хувьсгалын ойн баяр наадмын харваанд Буянт сумын уугуул Б.Батгэрэл 40 сумнаас 35 онож улсын мэргэн цол, одоо урианхай сурын дархан мэргэн, буриад сурын улсын хошой мэргэн болсон.


## Сурын харвааны цол тэмдэг

1998 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн Үндэсний их баяр наадмын харваанд 35 онож түрүүлэн. Улсын мэргэн цолоор шагнагдсан.



Монголын Урианхай сурын хөгжилд оруулсан хувь нэмэр, спортын амжилтыг үнэлж, Урианхай сурын улсын мэргэн цолоор 2000 оны 07 дугаар сарын 12-ны өдөр мөн 2007 оны

07 дугаар сарын 12-ны өдрийн Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 86 жилийн ойн баярын урианхай сурын харваанд 27 онож “Улсын хошой мэргэн” цолоор тус тус шагнагдсан.



2011 онд Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 он, Үндэсний Эрх чөлөөний хувьсгалын 90 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Буриад харваанд түрүүлж, цэц магнайгаар шалгарсан тул “БУРИАД ХАРВААНЫ УЛСЫН МЭРГЭН” цолоор шагнагдсан.



2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Их Монгол улс байгуулагдсаны 806 жил, Ардын хувьсгалын 91 жилийн ойн Үндэсний Их баяр Наадмын Урианхай сурын харваанд 28 онож Дархан мэргэн цолоор шагнагдсан.



**Құрметті \_\_\_\_\_!**

**Сізді Қазақстан Республикасы Ұлттық спорт түрлері Қауымдастығының  
ұйымдастыруымен өтетін «Жамбы ату спортын дамыту мәселелері»  
атты тәжірибелік семинарға шақырамыз.**

Өтетін уақыты: сағат 10.00 3 мамыр 2014 жыл

Өтетін орны: Түркістан қаласы, Тарихи-мәдени этнографиялық орталығы

2014 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Казакстан Улсын Үндэсний спортын төрлүүдийн холбооноос зохион байгуулж буй “Жамбы харваа спортын хөгжлийн асуудлууд” сэдэвт туршлага, солилцлох семинарт оролцсон. Жил бүр Баян-Өлгий аймгийн Өлгий суманд ээлжит олон улсын Бүргэдийн наадам болдог. Тус наадмыг Казакстан талаас анх удаа тусгай төлөөлөгчид ирж, тэмцээний хүндэт зочид болдог уламжлалтай байсан.

Тэд манай сум харвааны спортын хөгжлийн түвшинд онцгой анхаарал хандуулж, Казакстаны төлөөлөгчид сурын харвааны чиглэлээр ирж сургалт явуулах талаар тусгай санал тавьсан.

Мөн энэ нь зөвхөн Монголын сур харвааны төрлүүд төдийгүй, орон нутгийн Жамбы харваа” спортын төрлийг шинэ шатанл гаргах зорилготой алхам байсан юм.

## Олон улсад гарсан сэтгүүл ярилцлага:



Нүүр > Ярилцлага

### М.Батгэрэл: Зөвхөн эрчүүд харвадгаараа урианхай сур түлхүү хөгжих магадлалтай

Unuudur.mn 2019-06-14 13:00 © 1 мин



Үндэсний сурын улсын, буриад сурын улсын хошой, урианхай сурын харвааны улсын дархан мэргэн Мажирийн Батгэрэлтэй урианхай сур харвааны өв уламжлал, үүх түүх, түүний гаргасан амжилтын талаар ярилцлаа. Тэрбээр урианхай сур харвааны өв уламжлалыг тээн, олон жил харваж, бусдад заан сургаж яваа нэгэн билээ.

-Урианхай нь бусад сур харваанаас ялгарах ямар онцлогтой вэ?



М.Батгэрэлийн үр хүүхдүүд нь аавынхаа үлгэр дуурайллыг дагаж, бага наснаасаа урианхай сурын харвааг эзэмшиж, сургалт, дадлагад идэвхтэй оролцсоноор уг өвийг хойч үед уламжлуулах үйл ажиллагаанд шууд хувь нэмрээ оруулж байна. Тэд зөвхөн өөрсдийн ур чадвараа хөгжүүлэхээс гадна харвааны арга ухаан, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж байна. Ингэснээр уг өвийн тасралтгүй хадгалалт, хойч үед амжилттай дамжих баталгааг бүрдүүлж байгаа юм.


М.Батгэрэлийн ууган хүү Б.Мөнхсаруул –Спортын мастер, 2024 онд аймгийн Урианхай сурын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсэн.

Хүү Б.Тэнгисболд 2011 оны Үндэсний Их баяр наадмын Хүүхдийн харваанд шагналт 5 -байрнд шалгарсан ба Үндэсний их баяр наадмын Урианхай сурын төрөлд 5-байр эзэлж, “Спортын мастер”-ийн болзол хангасан. Мөн Батгэрэл овогтой Тэнгисболд нь 2012 он Үндэсний Их баяр наадмын Хүүхдийн харваанд 32 сумнаас 30 онож “Тэргүүн байр” эзэлж, Ипэр мэргэн цолоор шагнагдсан.

Хүү Б.Тэмүүжин 2018 оны Өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд “Тэргүүн байр” эзэлсэн.



2025 оны Урианхай сурын Улсын Аварга шалгаруулах тэмцээн Баян-Өлгий аймгийн Өлгий хотноо өргөн дэлгэр зохион байгуулагдаж өндөрлөсөн. 31 дэх удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Урианхай сурын Дархан Мэргэн, Үндэсний сурын Улсын Мэргэн, Буриад сурын Улсын Мэргэн М.Батгэрэлын нэрэмжит болов. УАШТ-нд МУСХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Баян-Өлгий аймгийн БТСГ, ЗДТГ-ын хамт олон оролцов. Урианхай сурын холбооны дэд ерөнхийлөгч Б.Энхболд, Дархан мэргэн М.Батгэрэл нарыг Баян-Өлгий аймгийн Хүндэт иргэнээр өргөмжлөв. Олон олон бахархалтай үйл явдал тохиосон Улсын аварга шалгаруулах тэмцээн боллоо.



М.Батгэрэлийн удирдлага, сургалтаар дамжуулан урианхай сурын харвааны өвийг эзэмшсэн шавь нараас аймаг, бүсийн чанартай тэмцээнд амжилттай оролцогчид, олон улсын уламжлалт харвааны арга хэмжээнд Монгол Улсаа төлөөлөн оролцсон харваачид бэлтгэгдэн төрөн гарсан.

**Урианхай сурын төрөлд амжилт гаргасан буй шавь нар:**

Урианхай сурын Улсын мэргэн Т.Очироо

Урианхай сурын Улсын мэргэн СМ Х.Алтансум

Урианхай сурын Улсын мэргэн СМ О.Эрдэнэбилэг

Урианхай сурын Улсын мэргэн СМ Ч.Одонгэрэл

Урианхай сурын Улсын мэргэн СМ Б.Батхуяг

Урианхай сурын Улсын мэргэн СМ Б.Ганхүү

Урианхай сурын Улсын мэргэн СМ Б.Батзориг

Урианхай сурын Улсын хошой мэргэн СМ Б.Мөнхтөр

Урианхай сурын Улсын мэргэн СМ Насанбат

Урианхай сурын Улсын мэргэн Х.Мягмаржав

Урианхай сурын төрөлд Спортын мастерын болзол хангасан 100 гаруй шавь нар бий





М.Батгэрэл нь ууган хүү болон Б.Мөнхсаруулын хамтаар “Тод баруун Алтай клуб”-ийг байгуулж, тус клубээр дамжуулан залуу харваачдыг сурган бэлтгэх, уламжлалт сурын харвааны өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.



“ТОД БАРУУН АЛТАЙ СУРЫН КЛУБ”-ээс Баян-өлгий аймгийн харваачдыгаа баяр наадамд бэлтгэл хийхэд нь зориулж сурын талбайд Үндэсний сурын зурхайг сайжруулж янзлах аяныг эхлүүлэн ажилласан.



2020 оны 10 дугаар сарын 11-ны өдөр клубээс зохион байгуулсан "Урианхай сур-2020" тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Уг тэмцээнд 50 гарам харваачид цэц мэргэнээ сорьсон.





Тод баруун Алтай клубын тамирчдын бэлтгэл сургалт




Монголын Хүүхдийн спортын VII наадмын анхан шат, байт харвааны өсвөр үеийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээн 2023 оны 4-сарын 16-ны өдөр БТСГ-ын "Б" зааланд зохион байгуулагдсан уг тэмцээн уралдаанд Тод баруун алтай клубын тамирчид амжилттай оролцсон.

дэлгэрүүлэхэд чиглэсэн бөгөөд зохион байгуулах үйл ажиллагаанд клуб, багш нар идэвх санаачилгатай оролцсон. Мөн энэхүү арга хэмжээг ивээн тэтгэн дэмжиж, бүх талын зохион байгуулалтын ажлыг хангаж ажилласан нь арга хэмжээний амжилт, үр бүтээлийг нэмэгдүүлсэн бөгөөд залуу харваачдыг сурган хөгжүүлэх, өв соёлыг хойч үедээ уламжлуулах үйл ажиллагааны үр дүнг бодитоор баталгаажуулсан юм.



Клубийн харваачид болон хүүхдүүдийн нийгмийн идэвхийг дэмжиж сурын талбайн хог цэвэрлэж мод усалсан.




2022 оны 05 дугаар сарын 08-ны өдөр клубийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэх зорилгоор нээлтийн харвааг зохион байгуулж, уламжлалт сурын харвааг сурталчлах, залуу харваачдыг дэмжих ач холбогдолтой арга хэмжээ амжилттай хэрэгжсэн болно.




Манай клубийн 2023 оны үйл ажиллагааны хүрээнд нээлтийн харвааг 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.



Баян-Өлгий аймгаас төрөн гарсан Монгол Улсын идэр мэргэчүүдийн нэрэмжит хүүхдийн сурын харвааг амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээ нь хүүхэд, өсвөр үеийн харваачдыг сургах, ур чадварыг хөгжүүлэх, уламжлалт сурын харвааны өвийг түгээн




2020 оны Үндэсний сурын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон манай клубын Өсвөрийн харваачид амжилттай харвасан.



2022 оны аймгийн Үндэсний сурын нээлтийн харваанд манай клубын харваачид амжилттай оролцсон.



Баян-Өлгий аймагт Урианхай сурын Баруун бүсийн чуулга харваа цуваа харваа



ОХУ-ын Барнаул хотод зохион байгуулагдсан арга хэмжээ

Монгол улсын үндэсний сурын мэргэн, Урианхай сурын дархан мэргэн, Буриад сурын хошой мэргэн Мичирийн Батгэрэл Монгол орны уулсын манлай төрийн тахилгат Алтай Ханы Таван Богд хайрханы тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолын их хүндэтгэлт дуут сум тавьлаа.



**УРИАНХАЙ СУРЫН  
ДАРХАН МЭРГЭН  
М.БАТГЭРЭЛ**



**УРИАНХАЙ СУР ХАРВАА БОЛ  
ЭРЧҮҮДИЙН НААДАМ ЮМ.**

**УРИАНХАЙ СУРЫН ӨВЛИЙН  
ХАРВАА БОЛОХ МӨСӨН СУР  
ХАРВААНД ЭМЭГТЭЙ  
ХАРВААЧ ХАРВАЖ  
БОЛОХГҮЙ.**

Шавьтайгаа хамт шагнал гардаж буй агшин



М.Батгэрэл нь урианхай сурын харваанаас гадна үндэсний өв соёлыг хамгаалах, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр гараараа дүйц сайтай, нарийн ур чадвартай урианхай үндэсний үүшүүр тоглоомыг хийж бүтээдэг. Тэрээр уг тоглоомыг сургалт, арга хэмжээ, тэмцээнүүдэд ашиглан залуу харваачид, хүүхэд, өсвөр үеийнхэнд уламжлалт соёлын мэдлэг, ур чадварыг дамжуулж, биет бус өвийг амьдруулан өвлүүлэхэд идэвх санаачилгатай оролцдог. Уг тоглоомыг арцны модоор хийдэг. Энэ тоглоом нь 1 арслан, 1 үнэг, 2 бар, 4 ирвэс, 8 буга, 16 хүдэр, 32 туулай, 64 шувуунаас бүрдэнэ.

